

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/004/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.03.21 № 01/231
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГА С.ӨЛЗИЙСҮРЭН
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангийн 2 зээлдэгчийн 27,662.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүг Монгол банкны мэдээллийн программд мэдээлээгүй, нас барсан 4 иргэн, хугацаа хэтэрсэн 23 иргэний 175,733.5 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийг хууль хяналтын байгууллагад өгч шийдвэрлүүлээгүй, мөн 19,000.0 мянган төгрөгийн зээл олгохдоо зээлийг графикт хугацаанд төлөх төлбөрийн чадваргүй иргэнд хамтран зээлдэгч буюу батлан даагчгүйгээр олгосноос Монгол банкны хар жагсаалтад орсон, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавиагүй, сүүлийн 3 жил дараалан дүгнэлт өгөхөөс татгалзсан, Эмийн эргэлтийн сангийн санхүүгийн тайлангаар нийт 3,120.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх" энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж,

210505204

байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Баян-Өнжүүл сум тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар Залуучуудыг дэмжих зорилгоор Спорт чийрэгжүүлэлт, Залуучуудын хөгжлийн төвийг 119,708.7 мянган төгрөгөөр, Ёслол хүндэтгэлийн өргөөг 141,504.4 мянган төгрөгөөр ахмадын өргөө сэргээн засварлалтын ажлыг 20,000.0 мянган төгрөгөөр, сурагчдын дотуур байрын их засварын ажлыг 164,563.2 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Бусад асуудал

Тус сум 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд 8 хөтөлбөр, 153 арга хэмжээг хэрэгжүүлж 87,05 хувьтай дүгнэгдсэн байна. Хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 88,6 хувь байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,416,869.5	1,502,928.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	344,346.8	321,944.7
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	884,419.7	971,373.9
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	188,103.0	209,609.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,837,590.9	3,591,211.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,837,590.9	3,591,211.1
39200	Биет хөрөнгө		1,751,127.4	1,910,125.4
39300	Биет бус хөрөнгө	13	86,463.5	1,681,085.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,254,460.4	5,094,139.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		111,676.6	30,368.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	111,676.6	30,368.6
41300	Өглөг	17а, 17б	111,676.6	30,368.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,142,783.8	5,063,770.8
51	Засгийн газрын хувь оролцоо		3,142,783.8	5,063,770.8
51100	Засгийн газрын оруулсан капитал		855,319.2	855,319.2
51200	Хуримтлагдсан үр дүн		1,875,588.2	3,796,575.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		411,876.3	411,876.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		3,254,460.4	5,094,139.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,008,470.5	4,300,971.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО		327,844.1	561,633.7
110	Орлогын албан татвар		178,072.7	334,368.8
1100	Хувь хүний орлогын албан татвар		188,072.7	334,368.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-10,000.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		62,104.8	102,301.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж		87,666.6	124,963.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	282,989.3	2,027,220.1
120	Нийтлэг татварын бус орлого		240,894.3	2,027,220.1
122	Тусламжийн орлого		42,095.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,397,637.1	1,712,118.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,427,453.0	2,379,984.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,243,031.8	1,588,438.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,087,224.5	1,548,821.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		378,279.4	675,659.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		47,575.6	81,561.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		47,260.1	371,541.0
2104	Хангамж, бараа материалын зардал		40,157.2	63,344.4
2105	Нормативт зардал		22,669.7	17,423.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,661.2	17,550.0
2107	Томилот, зочны зардал		5,547.8	9,436.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,		1,887.6	12,624.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		541,185.9	299,681.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,155,807.3	39,617.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		184,421.2	791,546.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		581,017.5	1,920,987.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-		581,017.5	1,920,987.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,561,766.3	2,561,766.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	15.9	15.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,561,782.2	2,561,782.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-15.9	-15.9
9	Тайлант үеийн үр дүн	581,017.5	581,017.5
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,142,783.8	3,142,783.8
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,142,783.8	3,142,783.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,142,783.8	3,142,783.8
19	Тайлант үеийн үр дүн	1,920,987.1	1,920,987.1
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,063,770.8	5,063,770.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,856,257.5	2,383,878.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	327,844.1	561,633.7
110	Орлогын албан татвар	178,072.7	334,368.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	188,072.7	334,368.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-10,000.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	62,104.8	102,301.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	87,666.6	124,963.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,070.7	6,768.5
1181	Газрын төлбөр	8,091.2	6,571.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	73,504.8	111,623.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	117,919.1	111,041.9
120	Нийтлэг татварын бус орлого	75,824.1	111,041.9
122	Тусламжийн орлого	42,095.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,410,494.3	1,711,203.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,262,773.3	1,448,828.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,262,773.3	1,448,828.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,106,966.0	1,409,300.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	378,279.4	660,283.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,177.7	81,561.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,286.9	371,127.3
2104	Хангамж, бараа материалын зардал	37,770.8	46,537.5
2105	Нормативт зардал	27,214.4	13,079.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,407.2	17,419.0
2107	Томилголт, зочны зардал	5,547.8	9,436.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,944.9	12,582.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	555,337.0	197,274.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,155,807.3	39,528.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	593,484.2	935,049.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	485,347.1	888,302.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	485,347.1	888,302.0
2200	Дотоод эх үүсвэрээр	485,347.1	888,302.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-485,347.1	-888,302.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-70,000.0	-69,150.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	70,000.0	69,150.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	38,137.1	-22,402.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	306,209.7	344,346.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	344,346.8	321,944.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,396,510.3	2,123,287.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,253,464.3	1,178,505.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,229,972.9	1,156,815.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	629,996.3	594,142.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,749.7	72,730.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	389,705.5	371,127.3
2104	Хангамж, бараа материалын зардал	30,355.7	29,516.4
2105	Нормативт зардал	1,000.0	1,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,150.0	19,839.1
2107	Томилолт, зочны зардал	11,518.0	8,756.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,712.8	21,412.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,784.9	38,291.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,491.4	21,689.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,491.4	21,689.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,023,046.0	875,632.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,000.0	69,150.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,396,510.3	2,026,620.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	622,030.2	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,353,464.3	1,960,706.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	421,015.8	65,914.6
4	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	150,835.2
5	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	54,168.9
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	52	52
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	4	4
650010	Гэрээт ажилтан	4	4
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	236,379.7	276,876.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	236,379.7	276,876.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	217,690.6	251,767.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,284.9	66,141.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,648.5	8,830.4
2104	Хангамж, бараа материалын зардал	-	15,730.1
2107	Томилолт, зочны зардал	-	680.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,402.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	192,757.2	158,982.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,689.1	25,108.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,015.2
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,689.1	9,093.6
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	236,379.7	276,876.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	236,379.7	276,876.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 110,968.7 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

Залруулсан алдаа:

Орлого, үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого тодруулга тайлантай 37,965.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Орлого, үр дүнгийн тайланд Эрүүл мэндийн төвийн 73,002.8 мянган төгрөгийн гүйцэтгэл татагдаагүй зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Залруулагдаагүй нийт 275,489.7 мянган төгрөгийн зөрчлөөс 206,562.0 мянган төгрөгийн материаллаг, 68,927.7 мянган төгрөгийн материаллаг бус зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 248,529.0 мянган төгрөгөөр хэтэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангийн 2 зээлдэгчийн 27,662.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүг Монгол банкны мэдээллийн программд мэдээлээгүй, нас барсан 4 иргэн, хугацаа хэтэрсэн 23 иргэний 175,733.5 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийг хууль хяналтын байгууллагад өгч шийдвэрлүүлээгүй, мөн 19,000.0 мянган төгрөгийн зээл олгохдоо зээлийг графикт хугацаанд төлөх төлбөрийн чадваргүй иргэнд хамтран зээлдэгч буюу батлан даагчгүйгээр олгосноос Монгол банкны хар жагсаалтад орсон, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавиагүй, сүүлийн 3 жил дараалан дүгнэлт өгөхөөс татгалзсан, Эмийн эргэлтийн сангийн санхүүгийн тайлангаар нийт 3,120.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх” энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина”, 10.4-т “Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чанаргүй активын ангилалд оруулж, Монгол банкны зээлийн

мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэнэ” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 68,927.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 68,927.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

3.2 Зөвлөмж

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд улсад төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлогыг 64,335.8 мянган төгрөг, орон нутагт төвлөрүүлэх 5 нэр төрлийн орлогыг 4,591.9 мянган төгрөгөөр, нийт 68,927.7 мянган төгрөгөөр орлого тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 04 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	110,968.7			2	110,968.7	2	110,968.7		
ИТХ	2	680.0			2	680.0	2	680.0		
Засаг даргын Тамгын газар	5	390,565.2	2	386,491.0	3	4,074.2	5	390,565.2		
ОНХС	1	93,356.8			1	93,356.8	1	93,356.8		
Цэцэрлэг	2	32,905.9			2	32,905.9	2	32,905.9		
Дүн	12	628,476.6	2	386,491.0	10	241,985.6	12	628,476.6		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	3	70,529.2	2	1,601.5			1	68,927.7
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	2,399.7					2	2,399.7
Засаг даргын Тамгын газар	3	4,873,050.5			1	4,715,106.6	2	157,943.9
Цэцэрлэг	1	667.1					1	667.1
Хоршоо хөгжүүлэх сан	3	206,562.0					3	206,562.0
Эмийн эргэлтийн сан	4	3,110.2	1	1,257.0	2	1,853.2	1	
Дүн	16	5,156,318.7	3	2,858.5	3	4,716,959.8	10	436,500.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ	1	0					1	00
ИТХ	1				1	0		
Цэцэрлэг	1	611,198.7					1	611,198.7
Дүн	1	611,198.7					1	611,198.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1				1		
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
4	Эмийн эргэлтийн сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	НИЙТ	5	1	4			1		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

